



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Увс аймгийн Татварын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9,990,000.00 (есөн сая есөн зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота Приус-20 маркийн, 30-85 УВА улсын дугаар, NHW200019240 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, нийт үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0245 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Увс аймгийн Татварын газрын дарга М.Галсүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 13?002370  
22-r huraldaan.docx